

АНТИВИРУСНЫ ПРОГРАММ ЭКМ/20260602234 ДУГААРТАЙ  
ШУУД ХУДАЛДАН АВАЛТЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Антивирус, Халдлага илрүүлэх Энтерпрайз систем (XDR) техникийн  
тодорхойлолт:**

<b>Системийн нэр</b>	ESET PROTECT Enterprise /кибер аюулгүй байдлын цогц шийдэл/
<b>Удирдлагын консоль (ESET PROTECT console)</b>	Үүлэн суурилсан (Cloud) болон дотоод серверт (On-Premise) суурилуулах хосолсон сонголттой, олон үйлдэлт нэгдсэн удирдлагын консольтой байна. Бүх төрлийн үйлдлийн системүүдийг (Windows, macOS, Linux, Android, iOS) алсын зайнаас нэг дороос удирдах, хянах боломжтой байна.
<b>Төхөөрөмжийн хамгаалалт (Modern Endpoint Protection)</b>	Сүлжээн дэх файл сервер, компьютер, лэптоп болон хөдөлгөөнт төхөөрөмжүүдийг хортой код (Malware), Exploit, Ransomware (барьцаалагч вирус), зорилтот болон файлгүй (Fileless) халдлагуудаас урьдчилан сэргийлж, илрүүлж, блок хийх чадвартай байна. Хөдөлгөөнт төхөөрөмжүүдийн удирдлага (MDM) болон мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх үндсэн функцуудыг агуулсан байна.
<b>Өргөтгөсөн илрүүлэлт, хариу арга хэмжээ (Extended Detection and Response - XDR)</b>	Эндпойнтуудын (End-points) идэвхжил, урсгалыг өргөтгөсөн байдлаар гүнзгий хянах (Threat Hunting) боломжтой байна. Сүлжээнд үүссэн кибер аюулгүй байдлын осол, аномаль үйлдлүүдэд нэн даруй автомат болон механик аргаар хариу арга хэмжээ авч, асуудлыг тусгаарлах шийдэлтэй байна.
<b>Ахисан түвшний хамгаалалт (Advanced Threat Defense)</b>	Үүлэн суурилсан Sandbox технологиор тоноглогдсон байна. Бүх бүртгэгдсэн сэжигтэй, үл мэдэгдэх файлуудыг тусгаарлагдсан Sandbox орчинд ажиллуулан туршиж, шинжилгээ хийх замаар Zero-Day (цоо шинэ) халдлага, шинэ төрлийн кодуудаас урьдчилан сэргийлдэг байна.
<b>Бүрэн диск шифрлэлт (Full Disk Encryption)</b>	Удирдлагын консолоос шууд зохицуулагддаг, Windows болон Mac үйлдлийн системүүдийн систем диск, партишн болон бүх дискийг бүхэлд нь шифрлэх (Encryption) чадамжтай байна. Төхөөрөмж гээгдэх, хулгайд алдагдах үед байгууллагын өгөгдлийн нууцлалыг бүрэн хангана.
<b>Серверийн аюулгүй байдал (ESET Server Security)</b>	Байгууллагын үндсэн серверүүд, OneDrive зэрэг сүлжээний файлын хадгалалт болон олон зориулалттай серверүүдээр дамжиж буй өгөгдлийг тасралтгүй сканердаж, бизнесийн тогтвортой байдлыг хангах модуль хэрэгсэлтэй байна.
<b>Лицензийн тоо</b>	150 ширхэг